

Байгалийн ургамал, амьтныг хамгаалах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд “Байгалийн ургамал, амьтны өнөөгийн төлөв байдал, цаашид авах арга хэмжээ”-ний тухай Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюуны илтгэлийг ажлын журмаар хэлэлцээд ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Монгол орны нэн ховор, ховор, унаган амьтан, ургамал, бичил биетний омог, эд, эсийн өсгөврийн сан, генобанк байгуулах ажлын санхүүжилтийг 2013-2015 онд шийдвэрлэж хэрэгжүүлэх;

2. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд мод, сөөг, сөөгөнцөр ургамал түлшинд хэрэглэхийг хязгаарлах зорилгоор түүхий нүүрсийг гүн боловсруулж цэвэр түлшээр төв, орон нутгийг хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлэх;

3. Эрсдэлийн менежментийн системийг нэвтрүүлж, амьтан, ургамал, бичил биетний эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн харь зүйлийг нутагшуулах зөвшөөрөл олгох тогтолцоо, чадавхийг бүрдүүлэх;

4. Ховордож устах аюулд өртсөн амьтан, ургамлыг байгалийн амьдрах орчинд нь хамгаалахыг чухалчлах, тэдгээрийн амьдрах орчныг тэтгэх биотехникийн арга, дүйцүүлэн хамгаалах механизмыг бий болгох;

5. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх замаар амьтан, ургамлын нөөцийг зохистой ашиглах загвар төслийг хэрэгжүүлэн, үр дүнг түгээн дэлгэрүүлэх;

6. Улаанбаатар - Замын Үүдийн хоорондох төмөр замыг хөндлөн нүүдэллэдэг амьтдын шилжилт хөдөлгөөн хаагдах, тархац нутаг хуваагдах эрсдэлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.